



Батлав:

“ХҮӨНДЭ ЭЛЕВАТОР МОНГОЛ” ХХК

Гүйцэтгэх захирал: А.Мөнхтуяа

ЦАХИЛГААН ШАТНЫ ТЕХНИК ҮЙЛЧИЛГЭЭ,
ЗАСВАРЫН АЖИЛ ГҮЙЦЭТГЭХ ГЭРЭЭ

Батлав:

ЦУС СЭЛБЭХ СУДЛАЛЫН
ҮНДЭСНИЙ ТӨВ

Ерөнхий захирал: Н.Эрдэнэбаяр

№ 16/09

2016 оны 09 сарын 20-ны өдөр

Улаанбаатар хот

Энэхүү гэрээг нэг талаас,

Улаанбаатар хот, Сүхбаатар дүүрэг, 4-р хороо, Сөүл 23 гудамж, Түшиг төвийн 2-р давхар 210 тоот хаягтай “ХҮӨНДЭ Элеватор Монгол” ХХК /цаашид “гүйцэтгэгч” гэх/ -г төлөөлж Ашиглалт үйлчилгээ хариуцсан албаны менежер албан тушаалтай Ө.Анхбаяр

Негөө талаас,

Улаанбаатар хот Баянзүрх дүүрэг 3-р хороо хаягтай “ЦУС СЭЛБЭХ СУДЛАЛЫН ҮНДЭСНИЙ ТӨВ” цаашид “үйлчилүүлэгч” гэх /-г төлөөлж Стратеги төлөвлөлт, санхүү бүртгэлийн албаны дарга албан тушаалтай Ч.Батболд / цаашид хамтад нь “талууд” гэх / нар нь Монгол улсын Иргэний тухай хуулийн 31 дүгээр бүлгийн холбогдох заалтуудыг удирдлага болгон дараах нөхцлөөр харилцан тохиролцож байгуулав.

Нэг. Гэрээний гол нөхцлүүд

- 1.1. Энэхүү гэрээгээр гүйцэтгэгч нь үйлчилүүлэгчийн хүсэлтийн дагуу цахилгаан шатны засвар болон техник үйлчилгээний ажил гүйцэтгэх, үйлчилүүлэгч нь хөлс төлөхтэй холбогдон талуудын хооронд үүсэх харилцааг зохицуулна.
- 1.2. Хэрэглэгчийн эрхийг хамгаалах үүднээс ажил, үйлчилгээ нь хэрэглэгчийн аюулгүй байдал, тоо, хэмжээ, чанар, хугацаа, зориулалтын зохих шаардлагыг хангасан байх зарчмыг баримтална.
- 1.3. Гэрээ нь талуудын эрх бүхий этгээдүүд гарын үсэг зурж тэмдэг дарснаар хучин төгөлдөр болох бөгөөд гэрээний дагалдах хавсралт, бусад баримт бичиг нь гэрээний салшгүй хэсэг байна.
- 1.4. Гэрээнд заасан үйлчилгээг 2016 оны 09-р сарын 20-өдөөс эхлэн үзүүлнэ.
- 1.5. Гэрээний хугацаа: Энэхүү гэрээ нь байгуулагдсанаас хойш 1 жилийн хугацаанд хүчинтэй байна.

Хоёр. Бүтээгдэхүүний техникийн тодорхойлолт

2.1 Гүйцэтгэгч нь үйлчилүүлэгчийн өмчлөлд байгаа 2.1.1-2.1.7-д заасан техникийн тодорхойлолт бүхий цахилгаан шатанд ажил үйлчилгээ үзүүлнэ.

- 2.1.1 Барилгын нэр: Цус сэлбэх судлалын үндэсний төв
- 2.1.2 Барилгын хаяг: Баянзүрх дүүрэг
- 2.1.3 Барилгын төрөл: Эмнэлэг
- 2.1.4 Цахилгаан шатны төрөл: Зорчигч

Гүйцэтгэгч тал.....

Үйлчилүүлэгч тал.....


- 2.1.5 Цахилгаан шатны техникийн дугаар: E12459 WBVF
- 2.1.6 Цахилгаан шатны техникийн үзүүлэлт: P1600-CO60-5FL/5ST LO1
- 2.1.7 Цахилгаан шатны тоо: 1

Гурав: Хөлс төлөх журам

- 3.1.1 Үйлчлүүлэгч нь доорх нөхцлийн дагуу хөлс төлнө.
- 3.1.2 Үйлчлүүлэгчийн цахилгаан шатанд засвар, техник үйлчилгээ үзүүлсний ажлын хөлсөнд / материал, сэлбэгийн үнэ орохгүйгээр **1 цахилгаан шатанд 110.000 /Нэг зуун арван мянган/ төгрөг**, төлөх ба энэ нь /НОАТ орсон дүн/ болно. Энэхүү төлбөрийг сар бүрийн 25-ны өдрийн дотор талууд баримт үйлдэн гүйцэтгэгч талын “ХАС БАНК” дахь төгрөгийн **5001094806** тоот төгрөгийн дансанд шилжүүлнэ.
- 3.1.3 Энэхүү гэрээний 3.1.1-д заасан хугацаанд үйлчлүүлэгч нь төлбөрөө төлөөгүй тохиолдолд хугацаа хэтэрсэн хоног тутамд гүйцэтгээгүй үүргийн үнийн дүнгийн 0.3 хувьтай тэнцэх хэмжээний алдангийг гүйцэтгэгч талд төлнө.
- 3.1.4 Гүйцэтгэгч нь үйлчлүүлэгч дуудлагаар очиж үйлчилгээ үзүүлэхдээ цахилгаан шатны сэлбэг хэрэгслэлийг солих шаардлага гарсан тохиолдолд эвдрэл гэмтлийг хоёр талын техникийн комиссын дүгнэлтээр тодорхойлж засварлан, сэлбэг хэрэгслэлийн үнийг үйлчлүүлэгч талд хариуцна.

Дөрөв. Үйлчилгээ үзүүлэх нөхцөл

- 4.1 Гүйцэтгэгч нь захиалагчид дараах хэлбэрийн үйлчилгээ үзүүлнэ.
- 4.1.1 Үйлчлүүлэгчийн дуудлагын дагуу 24 цагийн турш энэхүү гэрээний 2-д заасан хаягаар очиж үйлчилгээ үзүүлнэ.
- 4.1.2 Үйлчлүүлэгчтэй тохиролцсон хуваарийн дагуу сард нэг удаа цахилгаан шатны техникийн үзлэг оношлогоо хийнэ. Үзлэг хийсэн тухай акт үйлдэн үйлчлүүлэгч талын эрх бүхий этгээдээр гарын үсэг зуруулан баталгаажуулж, ихэмжлэлийг үйлдэн нэг хувийг үйлчлүүлэгч талд хүргүүлнэ.
- 4.1.3 Техникийн үзлэг оношилгоонд суурилсан нэмэлт засвар үйлчилгээг хийж гүйцэтгэнэ.
- 4.1.4 Цахилгаан шат эзэмшигч байгууллагын ашиглалтын буруугаас цахилгаан шатны эд анги эвдэрч гэмтсэн, тоногдсон, ашиглалтын горим алдсан буюу тасалгааны температурыг +5 хэмээс бага, уур ус, чийгтэй нөхцөлд ажиллуулсан, цанталт үүссэн тохиолдолд гүйцэтгэгч тал цахилгаан шатыг зогсоож техникийн хяналтыг үргэлжлүүлэн засвар үйлчилгээг хийж үйлчилгээний ажлын хөлсийг хийснээр ихэмжилнэ.
- 4.2 Ашиглалтын буруугаас шалтгаалсан гэмтэлд дараах зүйлсүүд орно.
- 4.2.1 Барилгын цахилгааны хэлбэлзэл,
- 4.2.2 Барилгын газардуулгын буруу холболт
- 4.2.3 Бүхээг, хонгилын хаалга болон дуудлагын аппарат, кнопны гадна нөлөөтэй гэмтэл, Бүхээг хонгилын хаалга болон дуудлагын аппарат, кноп эвдэрсэн тохиолдолд талуудын мэргэжилтнүүд тухайн гэмтлийг гадна нөлөөтэй гэдгийг тогтоосон
- 4.2.4 Цахилгаан шатаар зорчигчоос бусад зориулалтын бус ачаа зөөх, даац хэтрүүлэх, үүнтэй холбоотой үүссэн эд ангийн гэмтэл,
- 4.2.5 Хонгил руу ус алдан плат гэмтээх,
- 4.2.6 Туршилт тохиргоо болон засвар үйлчилгээг хийхдээ заавал үйлчлүүлэгч талын лифтчин болон цахилгаан шатыг хариуцсан эрх бүхий ажилтны хяналтан дор гүйцэтгэж сольсон сэлбэг, хийгдсэн засвар үйлчилгээний талаар тодорхойлолт, хүлээлцсэн акт бүрдүүлж нэг хувийг үйлчлүүлэгч талын хариуцсан ажилтанд хүлээлгэн өгнө.

Гүйцэтгэгч тал.....


Үйлчлүүлэгч тал.....



- 4.3 Гүйцэтгэгч тал цахилгаан шатны ашиглалтыг сайжруулах санал, зөвлөлгөөг үйлчлүүлэгчид өгнө.
- 4.3.1 Үйлчлүүлэгч тал цахилгаан шат хэвийн ажиллахгүй байвал саадгүй ажиллах нөхцлөөр хангахыг Гүйцэтгэгч талд тавьж гүйцэтгүүлэх.


Тав: Гүйцэтгэгч талын эдлэх эрх, хүлээх үүрэг

- 5.1 Гүйцэтгэгч нь гэрээний 4 дүгээр зүйлд заасан ажил үйлчилгээг чанарын шаардлага хангахуйц хэмжээнд хийж гүйцэтгэнэ.
- 5.2 Цахилгаан шатны ашиглалтын хугацааг уртасгах зорилгоор үйлчлүүлэгч талд “Цахилгаан шат төхөөрөмжлөх, аюулгүй ашиглах дүрэм” танилцуулж, санал зөвлөгөө өгч ажиллана.
- 5.3 Цахилгаан шатны эд анги эвдэрч гэмтсэн, тоногдсон, ашиглалтын горим алдагдсан, тасалгааны температурыг +5 хэмээс бага байлгасан, уур ус, чийгтэй нөхцөлд ажилшуулсан, цанталт үүссэн тохиолдолд гүйцэтгэгч тал цахилгаан шатыг зогсоох үүрэгтэй.
- 5.4 Гэрээний 5.3-д заасан нөхцлийг тургэн шуурхай арилгах техникийн хяналтыг гүйцэтгэж, холбогдох засвар үйлчилгээг хийнэ.
- 5.5 Лифтчинд цахилгаан шатыг цэвэрлэх, ашиглах горимыг танилцуулах үүрэгтэй.
- 5.6 “Лифтийг төхөөрөмжлөх аюулгүй ашиглах дүрэм”-ийн хүрээнд лифтний плат, эд ангиудыг эвдэрч гэмтэхээс урьдчилан сэргийлэх зорилгоор аливаа эвдрэл гэмтэл гарч болзошгүй нөхцөл байдлыг арилгахыг үйлчлүүлэгч талаас шаардах эрхтэй.
- 5.7 Цахилгаан шат хэвийн ажиллаж байсан ч ямар нэгэн сэлбэг дутуу бол сэлбэг хэрэгслийг солих хүртэл гүйцэтгэгч тал цахилгаан шатыг түр хугацаагаар унтраах үүрэгтэй
- 5.8 Гүйцэтгэгч нь гэрээт үүргээ дараах тохиолдолд түдгэлзүүлэх эрхтэй.
- 5.8.1 Үйлчлүүлэгч нь “Лифтийг төхөөрөмжлөх аюулгүй ашиглах дүрэм”-ийн 27 дугаар заалтын дагуу мэргэжлийн шаардлага хангасан орон тооны лифтчин ажиллуулаагүй,
- 5.8.2 Үйлчлүүлэгч гэрээний 3.1.2 дахь заалтыг биелүүлээгүй, төлбөр 2 /хоёр/ сараас дээш хугацаагаар хуримтлагдсан тохиолдолд гүйцэтгэгч тал гарч болзошгүй дуудлагыг хүлээн авахгүй ба цахилгаан шатыг төлбөрийн асуудал бүрэн шийдэгдтэл түр хугацаагаар унтраах эрхтэй.
- 5.8.3 Хуулийн дагуу шаардсан алдангийг төлөөгүй, тохиролцоонд хүрээгүй,
- 5.8.4 Үйлчлүүлэгч тал гэрээний үүргээ биелүүлээгүй

Зургаа: Үйлчлүүлэгч талын эдлэх эрх, хүлээх үүрэг

- 6.1 “Лифтийг төхөөрөмжлөх аюулгүй ашиглах дүрэм”-ийн 27.1 дэх заалтын дагуу лифтний бүрэн байдлыг хангаж ажиллана.
- 6.2 “Лифтийг төхөөрөмжлөх аюулгүй ашиглах дүрэм”-ийн 27.9-д заасны дагуу техникийн магадлалыг 12 сар тутамд нэгээс доошгүй удаа хийлгэж байна.
- 6.3 Зам тээвэр, барилга хот байгуулалтын Сайдын 53 дугаар тушаалаар батлагдсан “Лифтийг төхөөрөмжлөх аюулгүй ашиглах дүрэм”-ийн 27 дугаар заалтын дагуу мэргэжлийн шаардлага хангасан лифтчинтэй байх үүрэгтэй.
- 6.4 Хариуцсан лифтчин өөрийн эзэмшлийн цахилгаан шатанд өдөр тутмын ашиглалт, цэвэрлэгээг хийх үүрэгтэй.
- 6.5 Лифтний ашиглалт хариуцагч нь лифтний цахилгаан-механикч эсвэл цахилгааны буюу механикч инженер мэргэжилтэй хүн байна. Байгууллагад ийм хүн байхгүй бол “Лифтийг төхөөрөмжлөх аюулгүй ашиглах дүрэм”-ийн 27.10-д заасны дагуу тухайн байгууллагын дарга байна.
- 6.6 Лифтийн ашиглалт хариуцагч нь “Лифтийг төхөөрөмжлөх аюулгүй ашиглах дүрэм”-ийн 27.11, 27.15, 27.16-д заасан зүйлийг мэддэг байхын зэрэгцээ 27.12-д заасан үүргийг хүлээнэ.

Гүйцэтгэгч тал.....


Үйлчлүүлэгч тал.....


- 6.7 Гэрээ хийсэн тухайн байгууллага /СӨХ/, эсхүл эрх бүхий албан тушаалтан солигдох тохиолдолд гүйцэтгэгч байгууллагад мэдэгдэх ба урд сарын өр авлагыг гүйцэт дуусгаж хүлээж авах ба мэдэгдээгүй тохиолдолд шилжүүлсэн дараагийн байгууллага /СӨХ/ хариуцна.
- 6.8 Ашиглагдаж байгаа цахилгаан шатны эд анги, микросхем, дагалдах сэлбэг хэрэгсэл хулгайд алдагдах, үрэгдүүлэх, гадны нөлөөлтэй гэмтсэн, эвдэрсэн тохиолдолд үйлчлүүлэгч тал бүрэн хариуцна.
- 6.9 Гүйцэтгэгчийг гэрээгээр хүлээсэн үүргээ биелүүлэхийг шаардах эрхтэй.
- 6.10 Бүтээгдэхүүний үйлдвэрлэлт, тээвэрлэлтийн явцын талаарх бүрэн мэдээллийг нийлүүлэгч талаас авах эрхтэй.
- 6.11 Засвар үйлчилгээний чанартай холбоотой техникийн saat алт гэмтэл илэрвэл ажил гүйцэтгэгч байгууллагад яаралтай мэдэгдэж арга хэмжээ авахуулах эрхтэй.
- 6.12 Цахилгаан шат хүнтэй гацсан тохиолдолд эхлээд лифтний цахилгаан хүчдэлийг салгаж дараа нь зорчигчийг бүхээгнээс гаргаж, ажил гүйцэтгэгчид яаралтай мэдэгдэх арга хэмжээ авна.
- 6.13 Цахилгаан шатны эд анги плат хулгайд алдсан тохиолдолд үйлчлүүлэгч тал бүрэн хариуцна.
- 6.14 Цахилгаан шатны хонгил болон кабин доторх гэрэл шатсан тохиолдолд 3.1.4-д заасан нэмэлт нөхцлийг баримтлан үйлчлүүлэгч тал бэлдэх үүрэгтэй, шаардлагатай тохиолдолд гүйцэтгэгч талд дуудлага өгч сольж тавиулна.

Долоо: Бусад зүйл

- 7.1 Гэрээнд хоёр тал гарын үсэг зурж, тэмдэг дарснаар хүчин төгөлдөр болно.
- 7.2 Талууд харилцан тохиролцож анх гэрээ байгуулсан журмаар гэрээнд нэмэлт, өөрчлөлт оруулж болно. Нэмэлт өөрчлөлт оруулах тохиолдолд уг гэрээний загвар, нөхцөл, болзлыг засварлах, эсвэл өөрчилж болохгүй. Зайлшгүй шаардлагатай нэмэлт өөрчлөлтийн утга агуулгыг нэмэлт заалт болгон энэхүү гэрээний 9 дүгээр хэсэгт оруулж өгнө.
- 7.3 Хэрэв талуудын хооронд маргаан гарвал хэлэлцээрийн журмаар шийдвэрлэхийг эрхэмлэх ба маргаанаа шийдвэрлэж чадахгүйд хүрвэл шүүхээр шийдвэрлүүлэх эрх нээлттэй.
- 7.4 Гэрээний хугацаа дуусгавар болоход хоёр тал харилцан тохиролцсоноор гэрээний хугацааг сунгаж болно.
- 7.5 Барилгын ажил гүйцэтгэгч байгууллага тус гэрээг үйлчлүүлэгч талаас төлөөлж байгуулсаны дараагаар цахилгаан шатыг өөр байгууллагад хүлээлгэн өгч үйлчлүүлэгчийн нэр солигдсон тохиолдолд энэхүү гэрээний нөхцөл өөрчлөгдхөгүй бөгөөд гэрээ нэгэн адил хүчинтэй ба Нэмэлт өөрчлөлт бүлэгт шилжүүлэг хийсэн тэмдэглэл оруулна.
- 7.6 Шилжүүлэг нь гэрээний хугацаанд хүчин төгөлдөр үйлчилнэ.

Найм. Гэрээний сунгалт


- 8.1 Гэрээний хугацаа дуусгавар болохоос 7 хоногийн өмнө талууд гэрээнд ямар нэгэн санал, нэмэлт өөрчлөлт оруулаагүй тохиолдолд гэрээний хугацаа дахин 1 жилээр сунгагдсанд тооцож хүчин төгөлдөр үйлчилнэ.

Ес. Нэмэлт өөрчлөлт

9.1

.....
.....
.....
.....
.....

Гүйцэтгэгч тал.....


Үйлчлүүлэгч тал.....


9.2

ГЭРЭЭГ БАЙГУУЛСАН:

Гүйцэтгэгч талыг төлөөлж:

“Хүндэ Элеватор Монгол” ХХК

Албан тушаал: Ашиглалт үйлчилгээ

хариуцсан мэргэжилтэн

/ О.Анхбаяр /

Факс: 976-11-7016-3333

Харилцах утас: 7015-3333, 8908-3021

И-мейл хаяг: ankhbayar@hyundai-elevator.mn

Захиалагч талыг төлөөлж:

“Цус сэлбэх судалын үндэсний төв”

Албан тушаал: Страшени хөлөвьсөт
архив. бүртгэлтэй одаат
албан тушаалтай Гаргыз
Харилцах утас: 9904 2949

И-мейл хаяг:

Гүйцэтгэгч тал.....

Үйлчлүүлэгч тал.....